

МАЛ ХУЛГАЙЛАХ ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ АСУУДЛААР ИРГЭНЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДЛИЙН ТАНИЛЦУУЛГА

2014.10.29

Иргэн С.Доржоос мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх талаар арга хэмжээ авч өгөхийг хүсэж өргөдөл ирүүлснийг Өргөдлийн байнгын хорооны 2013 оны 03 тоот тогтоолоор баталсан журамд заасны дагуу УИХ-ын гишүүн М.Зоригт, Б.Чойжилсүрэн нар судлан танилцуулж байна.

Нэг. Өргөдлийг судалсан байдал

Өргөдлийн байнгын хорооноос иргэний өргөдлийг судлах хүрээнд Хууль зүйн яам, Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын холбогдох албан тушаалтнуудыг оролцуулсан дэд ажлын хэсгийг 2 удаа хуралдуулж, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Монголын үндэсний олон нийтийн радио телевизтэй хамтран Чингэлтэй дүүрэг дэх мал, махан бүтээгдэхүүн худалдан борлуулдаг “Хүчит шонхор” зах, Баянзүрх, Налайх дүүргийн дамжин өнгөрүүлэх пост дээр хяналт шалгалт хийж, үйл ажиллагаатай нь газар дээр нь танилцсан.

Түүнчлэн “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлгийг холбогдох бүх талуудыг байлцуулан зохион байгуулж, санал солилцсон. Мөн “Малчин” телевизтэй хамтран телевизийн шууд ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгуулав.

Холбогдох яам, мэргэжлийн байгууллага, албан тушаалтнаас мэдээлэл, лавлагаа авах тухай 6 албан бичиг хүргүүлж мэдээлэл, лавлагаа хүлээн авсан.

21 аймгийн Засаг дарга нарт хуулийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл ирүүлэхээр албан бичиг явуулснаас одоогийн байдлаар Баянхонгор, Говь-алтай, Дархан, Увс аймгууд мэдээлэл ирүүлээд байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг Эрүүгийн хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулж байна.

2004-2013 онд Монгол Улсын хэмжээнд зөвхөн мал хулгайлах гэмт хэрэг нийт 16,261 бүртгэгдсэн нь бусдын эд хөрөнгийг хулгайлах нийт гэмт хэргийн 24.1 хувийг эзэлж байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг анхан шатны нэгжид 21 аймгийн 330 суманд хэсгийн төлөөлөгч нар гүйцэтгэж байгаа бөгөөд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий цагдаагийн тасаг Дорнод, Хэнтий, Төв аймгуудад, цагдаагийн хэсэг Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Дархан, Дундговь аймгууд, Багануур, Налайх дүүргүүдэд ажиллаж байна. Цагдаагийн байгууллагын талаар авах арга хэмжээний тухай Засгийн газрын 2011 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан жишиг нормативын дагуу аймгууд дахь цагдаагийн газар, хэлтсүүдэд офицер 425, ахлагч 150, нийт 575 орон тоо дутуу, нэмэх асуудал шийдэгдээгүй мөн сумдын хэсгийн төлөөлөгч мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх цагдаагийн тасаг унаа, автомашинаар хүрэлцээ муутай байна.

Монгол Улсын Засгийн газраас Гэмт хэргийн тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн ба хуулийн төслийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Бусдын эд хөрөнгийг нууцаар, хүч хэрэглэхгүйгээр, хууль бусаар авсан бол дөчин цагаас зуун наян цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас таван жил хүртэл хугацаагаар эрх чөлөө хязгаарлах, эсхүл нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заажээ. Мөн Улсын Их Хурлын гишүүн Ё.Отгонбаяр мал хулгайлах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэмт хэргээс салгаж тусад нь гэмт хэргийн зүйл болгох талаар хуулийн төсөл санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хуулийн 145.2-т “Энэ гэмт хэргийг давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж буюу орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, **олон тооны мал хулгайлсан** бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заажээ.

Орон нутагт цагдаагийн албаны үйл ажиллагааг дэмжих зорилгоор сайн дурын үүсгэл санаачилгыг дэмжих, тухайлбал цэргийн дүйцүүлэх алба хаагчдыг эргүүл хийх, шуурхай мэдээлэл дамжуулах үйл ажиллагаанд татан оролцуулах боломжийн талаар авч үзэж болох ба энэ асуудлаар ХЗЯ, БХЯ-ны саналыг авсан болно.

Монгол Улсын иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-д “Монгол Улсын 18-25 насны, цэргийн хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэг бүхий иргэн шашин шүтлэг-ёс зүйн болон энэ хуульд заасан бусад шалтгаанаар цэргийн албыг дүйцүүлэн хааж болно. Цэргийн албыг дүйцүүлэн хаах хүсэлтэй иргэн онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын аврах анги, отряд, салбар Хилийн цэрэгт туслах хүчин болон хүмүүнлэгийн бусад байгууллагад алба хаана” гэж заажээ.

Мөн хуульд “Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаарыг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан аймаг, нийслэл бүрээр тогтооно” гэж заасны дагуу Засгийн газраас цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тооны дээд хязгаарыг 2013 онд 659, 2014 онд 714 байхаар баталжээ. Жил бүр улсын хэмжээнд 650-700 гаруй иргэн цэргийн дүйцүүлэх албыг хааж байна.

Хоёр. Хуулийн хэрэгжилтийн байдал

1/ Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн талаар:

2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.1, 145.2 дахь хэсэгт “Бусдын эд хөрөнгийг хулгайлсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. Энэ гэмт хэргийг давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон

бүлэг, машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж буюу орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, олон тооны мал хулгайлсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж тус тус заажээ.

Иймд мал хулгайлах үйлдэл нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 192000 төгрөгийн хэмжээнд хүрэхгүй тохиолдолд гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгож байна. Амьд малын үнэ ханш орон нутгийн онцлогоос хамааран ялгаатай байдаг бөгөөд дунджаар хонь, ямаа 120000-150000 төгрөгийн үнэтэй байна.

Иргэд, малчдаас сүүлийн 4 жилд малаа хулгайд алдсан талаар 9687 удаагийн дуудлага, мэдээлэл ирснээс 5050 буюу нийт хэргийн 52.1 хувьд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 47.9 хувьд нь эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байна. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан шалтгааны дийлэнх хувийг хохирлын хэмжээнд хүрэхгүй байгаа нөхцөл байдал эзэлж байна.

Мал хулгайлах гэмт хэргийн үйлдлийн арга, хэлбэр улам нарийсч, хохирлын хэмжээ өсч байгаа нь гэмт этгээдүүд тээврийн хэрэгсэл, мэдээлэл, харилцаа холбооны хэрэгслийг ашиглаж, урьдчилан үгсэн тохиролцож үйлддэг, бүлэг, зохион байгуулалтанд шилжсэнтэй холбоотой байна.

2/ Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийн байдал

Уг хуулийн дараах зүйл, заалтуудын хэрэгжилт хангалтгүй байна:

1. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт “Иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгаар мал сүргийг хамгаалах зорилготой малчид, мал бүхий иргэдийн бүлгийг баг, хороонд ажиллуулж болох бөгөөд бүлгийн **үлгэрчилсэн дүрмийг** хүнс, хөдөө аж ахуйн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална” гэж заажээ.

Энэхүү үлгэрчилсэн дүрмийг өнөөдрийг хүртэл батлаагүй байна. Харин Дархан-Уул аймагт 9, Говь-Алтай аймагт 64 иргэдийн бүлэг байгуулагдсан ажээ.

2. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад “...нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага төв суурин газар, хүнсний зах, махны үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж зэрэг шаардлагатай газарт **мал, мах бэлтгэх төвлөрсөн цэг тогтоож**, мал, махны гарал үүсэлд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж заажээ.

Баянхонгор, Говь-Алтай, Дархан-Уул, аймагт мал нядлах төвлөрсөн цэг байхгүй байна /бусад аймгууд мэдээ ирүүлээгүй/.

3. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтад “Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага шаардлагатай тохиолдолд хууль хяналтын байгууллагатай хамтран энэ хуулийн 7.1.1-д заасан им тамга, бүртгэлтэй тулгаж, хэсэгчилсэн буюу ганцаарчилсан **хяналтын тооллого** явуулах чиг үүргийг

хэрэгжүүлнэ” гэж заажээ. Гэвч **хяналтын тооллого** явуулсан орон нутгийн захиргааны байгууллага байхгүй байна.

Хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтад “Мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ... өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа малаа им тамга, бусад таних тэмдэгтэй болгох, бод малд зүсийн бүртгэл хөтлөх үүрэг хүлээнэ” гэж заажээ. Гэвч иргэд им тамга тавих, бод малд зүсийн бүртгэл хөтлөх үүргээ биелүүлэхгүй, энэ заалт хэрэгжихгүй байна. Иргэн энэ зүйлд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд 30 000 төгрөгөөр торгохоор заажээ. Харин нутгийн захиргааны байгууллага үүргээ биелүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар хуульд заагаагүй байна.

4.Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтад “Нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны бүх шатны байгууллага **бод малыг улсын хэмжээнд индексжүүлсэн тамгын сүлжээнд хамруулах** ажлыг зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж, 5.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 5.1.8-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг **хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална**” гэж, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэгт “Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх зорилгоор нийт малыг бүртгэх, бүртгэлийг тухай бүр шинэчлэх ажлыг **хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн** хариуцаж, холбогдох **бүртгэлийн журмыг батална**” гэж заажээ.

Хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасны дагуу “Бод малыг индексжүүлсэн тамгын сүлжээнд хамруулах журам”-ыг 2010 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтарсан 10/6 дугаар тушаалаар баталсан ба хуулийн 5.2 дахь заалт, 10.2 дахь заалт, 11.5 дахь заалт, холбогдох бусад хууль тогтоомжийг үндэслэн 2011 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/74 дугаар тушаалаар “Малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тухай” журмыг баталсан байна.

Дээрх журмуудад аль алинд нь сум, дүүргийн мэдээллийн сан, аймаг, нийслэлийн мэдээллийн сан, мэдээллийн үндэсний нэгдсэн сан байхаар заасан бөгөөд адууг тамгалах, чип суулгах, үхэр, тэмээг ээмэгжүүлэхээр давхардуулан заасан байна.

“Монгол мал” хөтөлбөрийн хүрээнд 2011 онд баталсан “Малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тухай” журмыг баримтлан малд ялган тэмдэглэгээг хийж, мэдээллийн нэгдсэн сан бий болгосон байна.

Журамд зааснаар мал эмнэлэг, үржлийн нэгжийн мэргэжилтнүүд адуунд уламжлалт тамгаас гадна арьсан дор чип тарьж суулган, бусад малыг ээмэгжүүлэн мал тус бүрт гэрчилгээ хөтлөн баталгаажуулж, харьяалах бүртгэл мэдээллийн албанд мэдэгдэж, мэдээллийн санд бүртгэнэ.

Ялган тэмдэглэх хэрэгсэл байршуулсан малын бүртгэлийг хийхдээ төрсөн улс орны кодыг үсгэн 2 тэмдэгтээр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн байршлыг 6, өрхийн кодыг 4, тухайн малын төрлийг 2, үүлдрийн кодыг 3, хувийн дугаарыг 12, хүйсийн кодыг 1 тэмдэгтээр тус тус тэмдэглэнэ.

2011 оноос хойш 38 000 адуунд чип суулгаж, 9.5 сая малыг ээмэгжүүлжээ. Үүний 50 хувийг үхэр эзэлж байна.

Ээмэгжүүлсэн малын ээмэг явцдаа хаягдах, мал нядалгаанд орсон зэргээс шалтгаалан одоо ойролцоогоор 7.3 сая мал ээмэгтэй байна. Эдгээр бүртгэл цаасан хэлбэрээр байгаагаас 1,7 сая бод малын бүртгэлийг цахим хэлбэрт оруулсан байна. Монгол Улсын хэмжээний нийт малыг бүртгэх, мэдээллийн санд оруулах ажил бүрэн хийгдээгүй байна.

5. Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “**Сум, дүүрэг, баг, хорооны Засаг** дарга мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас төв суурин газарт борлуулах, худалдах зорилгоор оруулж байгаа мал, маханд мал, мах **бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ** олгоно” гэж, 10.2 дахь хэсэгт “Мал, мах бэлтгэх гарал үүслийн гэрчилгээний загвар, олгох журмыг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж, Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т “**Мал эмнэлэг, үржлийн хэрэгжүүлэгч байгууллага** нь ... мал, түүний үржлийн чанар, ашиг шим, эрүүл мэнд болон малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд үзлэг, шинжилгээ хийж **гарал үүсэл, чанарыг** тодорхойлж гэрчилгээ олгоно” гэж тус тус заажээ.

Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2005 оны 35 дугаар тушаалаар “Мал эмнэлэг, ариун цэвэр-гарал үүслийн гэрчилгээ, түүнийг хэрэглэх журам”, загварыг баталсан байна.

Одоогоор дээрх журмын дагуу гарал үүслийн гэрчилгээг олгож байгаа хэдий ч гарал үүслийн гэрчилгээнд тавих хяналт алдагдсан, түүнийг хэвлэх, зарцуулах, олгох үйл ажиллагаа хяналтгүй, хувийн хэвлэлийн компанид гэрчилгээг хэвлэх боломжтой, мал, эмнэлгийн арга хэмжээний хэрэгжилтийг дутуу бичдэг, үлдэх хувийг бичдэггүй, зэрэг зөрчлүүд нийтлэг байна.

Түүнчлэн дээрх 2 хуульд гарал үүслийн гэрчилгээг сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга болон мал эмнэлэг, үржлийн хэрэгжүүлэгч байгууллага аль аль нь олгохоор заасан нь хоорондоо зөрчилдөж байгаагаас гадна “Малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх тухай” журмын 6.2.2-т “Энэхүү журмын 3 дугаар хавсралтаар тодорхойлогдсон, тухай төрлийн малын амьдралын хугацааны онцлог чанарыг бүртгэлээр дамжуулан ялган тогтооход шаардагдах мэдээллийг багтаасан албан ёсны гэрчилгээг малын бүртгэлийн буюу гарал үүслийн гэрчилгээ гэж үзнэ” гэж дээрх заалтуудаас өөрөөр тодорхойлсон байна.

Хууль бусаар гэрчилгээ олгосон тохиолдолд Засаг дарга болон мал эмчид хүлээлгэх хариуцлагын талаар Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд заагаагүй байна.

6.Хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт “Мал бүхий иргэн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэг нэгжээс өөр нэгжид түр хугацаагаар оторлох болон тууварлах, шилжин суурьших тохиолдолд тухайн малчин **малдаа бүртгэл хөтөлнө**” гэж, 12.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 12.1-д заасан бүртгэлд малын төрөл, тоо толгой, нас, хүйс, зүс, им тамга, оторлох нутаг, хугацаа, оторлох, тууварлах буюу шилжин суурьших засаг захиргааны нэгжийг заах бөгөөд уг бүртгэлийг тухайн сум, дүүргийн **Засаг дарга батламжилна**” гэж тус тус заажээ.

Увс аймгийн мэдээлэлд энэ заалтын дагуу малчны бүртгэлийг сумын Засаг дарга батламжилдаг эсэх талаар дурдаагүй, хөдөөгийн малчдын онцлогт тохируулан өөрчлөх шаардлагатай гэсэн саналыг Баянхонгор аймгийн нутгийн

захиргааны байгууллагаас ирүүлснээс үзэхэд энэ заалт хэрэгждэг эсэх нь тодорхойгүй байна.

Түүнчлэн малчны бүртгэлийг батламжлах журам, хугацаа, хүлээлгэх хариуцлагыг хуульд заагаагүй байна.

7.Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Сум, дүүргийн нутаг дэвсгэрээр мал туувар дайран өнгөрөх **орон нутгийн тууврын замын маршрутыг тухайн сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал**, бүсийн маршрутыг Бүсийн захирагч, бүс хоорондын маршрутыг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Бүсүүдийн захирагч нартай хамтран тус тус тогтооно” гэж заажээ.

Хуулийн энэ заалтын дагуу орон нутгийн тууврын замын маршрутыг Баянхонгор, Говь-Алтай, Увс, Дархан-Уул аймагт өнөөдрийг хүртэл тогтоогоогүй байна. /Бусад аймгаас мэдээлэл ирүүлээгүй байна/

8.Хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, 16.3 дахь хэсэгт “Энэ хуулийн 4.1-д заасан салбар зөвлөлийн дэргэд мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх **тусгай сан байгуулж болно**. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн үлгэрчилсэн дүрмийг Засгийн газар батална. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн **дүрмийг орон нутгийн онцлогт тохируулан батална**” заажээ.

Засгийн газрын 2005 оны 2 дугаар тогтоолоор “Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх сангийн үлгэрчилсэн дүрэм”-ийг баталсан хэдий ч орон нутгуудад энэ зориулалтын санг бий болгоогүй, дүрмийг батлаагүй байна.

Зөвхөн Говь-Алтай аймгийн зарим сумдад энэ санг бий болгосон ч хөрөнгийг бүрдүүлээгүй тухай мэдээлэл байна.

Сангийн үлгэрчилсэн дүрэмд сангийн хөрөнгийг **гадаад, дотоодын иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн тусламж, хандив болон хуулиар хориглоогүй бусад эх үүсвэрээс** бүрдүүлэн мал хулгайлах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг судлах, арилгах, энэ чиглэлийн үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсийг урамшуулахад зарцуулахаар заажээ.

9.Хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтад “Мал, мах бэлтгэлийн зориулалтаар **гарал үүслийн гэрчилгээгүй** мал тууварласан, мал, мах тээвэрлэсэн, тусгайлан бэлтгэсэн төвлөрсөн цэгээс өөр газарт мал, мах бэлтгэсэн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол **хууль бусаар тууварласан, тээвэрлэсэн, бэлтгэсэн мал, махыг болон зөрчил гаргахад ашигласан уналга, тээврийн хэрэгслийг хураан зөрчлийг илрүүлсэн орон нутгийн төсвийн орлого болгож**, зөрчил гаргасан иргэнийг 50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 250000 төгрөгөөр торгоно” гэж заажээ.

Гэвч хууль батлагдсанаас хойш 10 жилийн хугацаанд нэг удаа Хэнтий аймагт зөрчил гаргахад ашигласан тээврийн хэрэгслийг хураан авч орон нутгийн орлого болгосон байна.

Цагдаагийн байгууллага шүүхээр шийдвэрлэснээс бусад тохиолдолд хувийн

өмчид халдахгүй гэж үзэн тээврийн хэрэгслийг хураадаггүй хандлагатай байна.

Хууль бус мал, махан бүтээгдэхүүнийг илрүүлсэн тохиолдолд түүнийг хураан авч, хадгалах агуулах, байр байхгүй гэсэн шалтгаанаар хуулийн дээрх заалт хэрэгжихгүй байна.

Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр Хууль зүйн яам, Цагдаагийн ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас дараах саналуудыг ирүүлсэн. Үүнд:

- Хууль, холбогдох журмуудыг шинэчлэн боловсронгуй болгох (ХЗЯ, МХЕГ);
- Бод малд чип суулгах, малыг ээмэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, бүртгэлийн системийг боловсронгуй болгох (ХЗЯ, ЦЕГ, МХЕГ);
- Малын гарал үүслийн гэрчилгээнд тавих хяналтыг сайжруулах (ЦЕГ);
- Мал, мах бэлтгэх тогтолцоонд өөрчлөлт хийх (ЦЕГ);
- Малчдын малын хариулга, маллагааг сайжруулах (ЦЕГ);
- Гэмт хэрэг үйлдэх замаар олсон мал, мах, түүхий эдийг худалдан авсан, зарж борлуулсан, энэ төрлийн гэмт хэргийг үйлдэхэд оролцсон этгээд /ченж нар/-эд хүлээлгэх хариуцлагыг чангатгах (ХЗЯ);
- Мал хулгайлах гэмт хэргийн шийдвэрлэлт, мөрдөн шалгах процессыг шинэчлэх (ЦЕГ);
- Эмээлт, Хүчит шонхор, Налайх зэрэг төвлөрсөн цэгүүдэд тавих хяналтыг сайжруулах. хяналтын камер суурилуулах (ХЗЯ, ЦЕГ);
- Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн идэвхийг нэмэгдүүлэх, дэмжих (ХЗЯ);
- Мал, махыг Хөдөө аж ахуйн биржээр дамжуулан худалдаалдаг болох (ХЗЯ, МХЕГ).

Хоёр. Санал, дүгнэлт

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна. Энэ нь хуульд заасан мэдээллийн нэгдсэн сан байгуулах, гарал үүсэл, ариун цэврийн гэрчилгээ олгох, бүртгэх, хяналт тавих тогтолцоо бүрдүүлэх асуудал өнөөдрийг хүртэл цэгцрээгүй байгаатай холбоотой бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтанд хуулиар хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг хуульд заагаагүй зэрэг нь хуулийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.

Хуулийн хүрээнд батлагдсан журмууд нь хоорондоо уялдаагүй, амьдралд нийцэхгүй заалт ихтэй, журамд зааснаар мэдээллийн санг бүрдүүлэхэд их хэмжээний өртөг зардал, хүн хүч шаардагдахаар /үргүй зардал/ байгааг анхаарч одоогийн улсын мал тооллогын дүн, цагдаагийн байгууллагад хэрэглэж буй сүлжээтэй уялдсан, гарал үүслийн гэрчилгээ, бүртгэл, шилжилт хөдөлгөөнийг шуурхай оруулах болон хууль хяналтын байгууллагууд шууд хандах боломжтой байдлаар оновчтой болгон зохицуулах шаардлагатай байна.

Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэмт хэргээс мал хулгайлах гэмт хэргийг тусад нь гэмт хэргийн зүйл болгон оруулах эсэх асуудлаар Байнгын хорооны гишүүдийн саналыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороонд хүргүүлэх нь зүйтэй байна.

Хуулийн хэрэгжилтэд тавих салбарын яам, агентлагуудын дотоод хяналтыг сайжруулахын зэрэгцээ тэдгээрт хяналт тавих хөндлөнгийн хяналт буюу

мэргэжлийн хяналтын тогтолцоог бэхжүүлэх шаардлагатай байна.

Өргөдлийн байнгын хорооноос Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах чиглэлээр судлан шаардлагатай тохиолдолд хуулийн төсөл боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх чиглэлийг Засгийн газарт өгөх нь зүйтэй гэж үзэв. Үүнд:

1. Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэгт заасан иргэдийн сайн дурын үүсгэл санаачилгаар мал сүргийг хамгаалах зорилготой малчид, мал бүхий иргэдийн бүлгийн үлгэрчилсэн дүрмийг батлах /ХЗЯам/;
2. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д заасны дагуу мал, мах бэлтгэх төвлөрсөн цэг тогтоох /Нутгийн өөрөө удирдах байгууллагууд/;
3. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.7, 7 дугаар зүйлийн 7.1.1-д тус тус заасны дагуу малчдыг өөрийн малаа им тамга, бусад таних тэмдэгтэй болгох, бод малд зүсийн бүртгэл хөтлөх ажлыг хэвшүүлэх арга хэмжээ авах, нутгийн захиргааны байгууллагаас им тамга, бүртгэлтэй тулгаж хяналтын тооллого явуулж байх /Нутгийн захиргааны байгууллагууд/;
4. Хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 10 дугаар зүйлийн 10.2, 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэгт заасан бод малын индексжүүлсэн тамгын сүлжээ, мэдээллийн нэгдсэн сан, мал, мах бэлтгэлийн гарах үүслийн гэрчилгээтэй холбогдох журмуудыг шинэчлэн батлах, журам хоорондын уялдааг хангах, /ХЗЯ, ҮХААЯ/;
5. Хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасны дагуу малчны оторлох болон тууварлах, шилжин суурьших тохиолдолд хөтлөх бүртгэлийг сум, дүүргийн Засаг даргаас батламжлах үйл ажиллагааг тодорхой болгох;
6. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт заасны дагуу орон нутгийн мал тууврын маршрутыг тогтоох;
7. Хуулийн 16 дугаар зүйлд заасан мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тусгай сангийн зохицуулалтыг сайжруулах, хөрөнгийг бүрдүүлэхэд анхааран орон нутгуудад тусгай санг бий болгох, Малын индексжүүлсэн даатгалын хөрөнгөөс уг санд төвлөрүүлэх боломжийн талаар судлан үзэх;
8. Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй төрийн албан тушаалтан, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, дамжуулан борлуулагч нарт хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох;
9. Орон нутагт мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх Цагдаагийн байгууллагын чадавхийг нэмэгдүүлэх;
10. Цэргийн дүйцүүлэх алба хааж буй иргэдийг оршин суугаа нутаг дэвсгэрт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журмыг хамгаалах арга хэмжээнд татан оролцуулах.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН М.ЗОРИГТ, Б.ЧОЙЖИЛСҮРЭН